# APS Canvas

## гэрээс суралцах хугацаанд iPad ашиглаж буй сурагчдад тусалж буй эцэг эхчүүдэд зориулав

Энэ материалд дараахыг үзүүлэв:

- Сурагчид Canvas Сурагчийн апп-д хэрхэн нэвтрэх тухай
- Canvas Сурагчийн аппын тухай видео танилцуулга
- Самбар болон тохиргоо хийх Canvas заавар
- Хичээлийн үйлдлүүдийн  Canvas заавар
- Даалгаврын Canvas заавар
- Хүртээмжтэй байдлыг хангах арга хэрэгслүүд

Энэ холбоос дээр дарж iOS-д зориулсан Canvas Сурагчийн аппын бүх зааврыг харна уу

Шин.
4/3/2020

# Canvas Сурагчийн апп руу нэвтрэх

APS сурагчдын iPad дээр Canvas Сурагчийн апп хэдийнээ суусан байгаа. Энэхүү илтгэлээр хэрхэн нэвтэрч, Canvas Сурагчийн аппыг хэрэглэх талаар үзүүлнэ. Зарим сурагчид болон багш нар iPad дээрх Safari браузераар Canvas руу холбогдох дуртай байдаг.  Браузераар холбогдох талаарх мэдээллийг ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕРЫН ИЛТГЭЛ ХОЛБООСНООС авна уу.

1




Сурагчийн iPad дээр **Canvas Сурагчийн аппыг** олно уу.  Та нүүр дэлгэц дээр хуруугаа доош гүйлгэн Canvas гэж бичин хайлт хийж болно. Аппын таних тэмдэг дээр дарна уу.

2




Энэ дэлгэц дээр **Өөрийн сургуулиа олох** товчийг дарна уу.
ТАЙЛБАР: Сургуулийн нэрээ **бүү** шивээрэй.

3




"Өөрийн сургууль эсхүл дүүргийг олох" нүдэнд, "**Arlington Public Schools**" гэж шивж эхэлнэ үү.  Хоёр сонголт гарч ирнэ.   **Сурагчид/Багш нар** гэснийг нь сонгоно уу.

4




Энэ дэлгэц дээр сурагчид **Сурагчийн ID** болон **Нууц үгээ** оруулан **Go** товчийг дарна.

# Видео: Canvas Сурагчийн аппын танилцуулга

**Canvas Сурагчийн аппын** танилцуулга бүхий Canvas-ын найруулсан видеоны холбоос болох зургийг дарна уу.

Видео нь ерөнхий нэвтрэх үйл явцаар эхэлнэ, иймд **видео :49 хүртэл гүйлгэнэ үү**.



# Canvas Сурагчийн аппын заавруудын холбоос (iOS) - Тохиргоо ба самбар

Canvas Сурагчийн апп нь сурагчдад өөрсдийн хичээлд хандалт хийхэд тусалдаг. Апп нь таны профайл, хуанли, хийх зүйлсийн жагсаалт, мэдэгдэл болон мессежийг харуулахын зэрэгцээ аливаа хичээлд хандах болон түүнийг дүүргэхэд шаардлагатай үйлдлүүдийг агуулна.

**Доорх холбоосууд дээр дарж илүү мэдээлэл авна уу.**

**Би хэрхэн:**

- Сурагчийн аппыг хэрэглэх вэ?
- Сурагчийн аппын тохиргоог хийх вэ?

**Сурагчийн апп дотор би хэрхэн:**

- Хуанлийг харах вэ?
- Мессеж илгээх вэ?
- Харилцан ярианы ирсэн шуудан дахь мессежинд хариулах вэ?
- Мэдэгдлүүд харах вэ?
- Хийх зүйлсийн жагсаалт харах вэ?




*Жишээ самбар*

Энэ холбоосыг дарж iOS-д зориулсан бүх Canvas Сурагчийн апп зааврыг харна уу

# Canvas Сурагчийн аппын заавруud (iOS) - Хичээлийн үйлдлүүд

Аппын үндсэн нүүр нь **Самбар** байх ба таны дуртай хичээлүүдийг харуулна. Хичээлийг нээхийн тулд, хичээлийн нэрийг товшино уу. Хэд хэдэн APS багш нарын **Нүүр хуудас** дээр Модулиудын холбоос байдаг.

**Доорх текстэн холбоосуудыг дарж Хичээлийн үзүүлэлтүүдийн талаар дэлгэрэнгүй мэдэж аваарай.**

**Би хэрхэн:**

- Хичээлүүд болон Бүлгүүдээ харах вэ?
- Зарлалууд харах вэ?
- Хурлууд харах вэ?
- Хэлэлцүүлгүүд харах вэ?
- хэлэлцүүлэгт хариулах вэ?
- Rich Content Editor ашиглах вэ?
- дүнгээ харах вэ?
- Модулиудаа харах вэ?
- сорилоо харах вэ?
- сорилын үр дүнг харах вэ?

*Жишээ хичээл*




Энэ холбоосыг дарж iOS-д зориулсан бүх [Canvas Сурагчийн апп зааврыг](#) харна уу

# Canvas Сурагчийн аппын заавруud (iOS) - Даалгаврууд

Багш нар Canvas ашиглан илгээх даалгаврууд өгч болно. Олон төрлийн даалгаврууд бий. Доорх холбоос нь тодорхой төрлийн даалгавар илгээх болон санал тайлбар ирсэн тохиолдолд тэдгээрт хэрхэн хандах зэрэгт туслах iOS-т зориулсан Canvas Сурагчийн аппын заавруud юм.

Доорх холбооснууд дээр дарж, даалгавруудын талаар илүү мэдээлэл авна уу.

Би хэрхэн:

- даалгавраа харах вэ?
- даалгаврын талаар сэтгэгдэл бичих вэ?
- өөрийн даалгаврын үнэлэх зарчмыг харах вэ?
- илгээх даалгавар болгон файл оруулах вэ?
- илгээх даалгавар болгон медиа файл оруулах вэ?
- илгээх даалгавар болгон вэб хуудасны URL оруулах вэ?
- текст оруулсан даалгавар илгээх вэ?
- тэмдэглэл бүхий PDF даалгавар илгээх вэ?
- гуравдагч этгээдийн аппнаас даалгавар илгээх вэ?
- даалгавраа илгээгдсэн болохыг баталгаажуулах вэ?
- даалгавар дахин илгээх вэ?
- илгээх даалгаварт тэмдэглэл нэмэх вэ?
- багшаас даалгавар дээр үлдээсэн сэтгэгдлийг харах вэ?

Энэ холбоосыг дарж iOS-д зориулсан бүх Canvas Сурагчийн апп зааврыг харна уу

# Хүртээмжтэй байдлыг хангах арга хэрэгслүүд

Программ болон төхөөрөмжид анхнаас нь суурилагдсан хүртээмжтэй байдлыг хангах төрөл бүрийн арга хэрэгсэл байдаг.

## Canvas дотор

- Canvas дахь хүртээмжтэй байдал (браузер)
- Canvas хуудаснуудад Идэвхжүүлэх уншигч байдаг *(Зарлал, хэлэлцүүлэг, даалгавар, сорилууд зэрэгт байхгүй). Бид iPad дээр Safari дээр туршсан бөгөөд энэ браузер дээр ажиллаж байсан (Canvas сурагчийн апп нээж удирдлагуудад харах эсэхийг асуусан баннерыг хаасан болохыг нягтална уу). Идэвхжүүлэх уншигч нь сурагчийн апп дээр байхгүй, гэхдээ чангаар уншуулахын тулд сурагчид iPad дээрх хүртээмжтэй байдлыг хангах арга хэрэгсэл болгон суурилуулсан текстийг яриа болгох үйлдлийг ашиглаж болно (Тохиргоо > Хүртээмжтэй байдал > Яриа > Яриа сонголтыг асаах. Дараа нь Текст гэснийг сонгоод Ярих гэдгийг сонгох).*

## iOS төхөөрөмжид суурилагдсан

- iPad/iPhone-д зориулсан хүртээмжтэй байдлын дөт үйлдэл
- iPad/iPhone-д зориулсан хүртээмжтэй байдал - шилмэл заавар

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа хэрхэн харах вэ?

Баримт бичгийг Canvas Doc багийн 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулав•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 36

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Canvas Сурагчийн апп нь танд бүх хичээлээ даалгавраа хянахад тусалдаг. Түүнчлэн та Мэдэгдэл цэсээс шинээр үүсгэсэн даалгаврууд харах буюу даалгаварт оруулсан өөрчлөлтийг мөн харах боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:** Хичээлийн хөтөч цэс нь таны Canvas хичээлийн браузерын хувилбарт нийцсэн байна. Хэрэв Хичээлийн хөтөч дотор даалгавар байхгүй байвал апп дотор мөн харагдахааргүй нуусан байдалд байна.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

### Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх хэрэгтэй байж магад.

## Даалгавар харах




Canvas Сурагчийн апп дотор даалгавруудыг даалгаврын бүлгээр ангилсан байна [1]. Та мөн даалгавруудаа дүгнэх хугацаагаар шүүн харах боломжтой [2].

## Даалгавар нээх




Даалгавар харахын тулд даалгаврын нэр дээр товшино уу.

## Даалгаврын дэлгэрэнгүйг харах




Даалгаврын дэлгэрэнгүй хуудас нь даалгаврын гарчиг, авч болох оноо, илгээгдсэн эсэх төлөв болон хураалгах эцсийн хугацааг харуулна [1]. Түүнчлэн та мөн даалгавар илгээх арга замын төрөл [2], хэрэв багш тань хязгаарлалт тавьсан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх файлын төрлүүдийг харж болно [3].

Илгээсэн даалгаврын дэлгэрэнгүй болон даалгаврын үнэлэх зарчмыг харахын тулд, **Илгээсэн даалгавар & Үнэлэх зарчим** холбоосыг товшино уу [4].

Түүнчлэн та даалгаврын тайлбарыг мөн харах боломжтой [5].

Даалгавраа илгээхийн тулд, **Даалгавар илгээх** товчийг товшино уу [6].

### Даалгавар илгээх




Сурагчийн апп нь даалгавар илгээх дараах төрлүүдийг дэмждэг:

- Текст оруулах
- Вэб хуудасны URL хаяг
- Медиа бичлэг
- Файл оруулах
- Canvas Studio

### Түгжигдсэн даалгаврууд харах




Хэрэв даалгаварт хандах боломжгүй байгаа тохиолдолд Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа тухайн даалгавар нээгдэх огноо, цагийг харуулна.




Хэрэв даалгаварт хандаж болох хугацаа хэтэрсэн бол, Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа тухайн даалгавар түгжигдсэн огноо болон хугацааг харуулна.

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор Хичээлийн хөтөлбөрийг хэрхэн харах вэ
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор ямар нэг даалгаврын талаар хэрхэн сэтгэгдэл оруулах вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа хэрхэн харах вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор ямар нэг даалгаврын талаар хэрхэн сэтгэгдэл оруулах вэ?

Canvas Doc багийн ажилтнууд 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтнууд 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 38

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та даалгавар дээр асуулт асуух эсхүл тайлбар оруулах зорилгоор сэтгэгдэл үлдээх боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

### Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх




Даалгаврын нэр дээр товшино уу.

## Илгээсэн даалгавар болон үнэлэх зарчмыг нээх




**Илгээсэн даалгавар & үнэлэх зарчим** холбоосыг товшино уу.

## Илгээсэн даалгавар дахь сэтгэгдлийг нээх




Илгээсэн даалгаврын дэлгэрэнгүй хуудас дээр, сэтгэгдэл цэсийг дээш нь гүйлгэнэ үү.

## Текстэн сэтгэгдэл нэмэх




Текстэн сэтгэгдэл нэмэхийн тулд, **Сэтгэгдэл** нүдийг товшин, өөрийн текстийг шивнэ үү [1]. **Илгээх** товчийг дарж өөрийн сэтгэгдлийг илгээнэ үү [2].

# Медиа хэлбэрийн сэтгэгдэл нэмэх




Сэтгэгдлийн өөр төрөл нэмэхийн тулд, сэтгэгдлийн нүдний дэргэдэх **Нэмэх** таних тэмдгийг товшино уу [1]. Та аудио бичлэг хийж сэтгэгдэл үлдээж [2], видео бичлэг хийж сэтгэгдэл үлдээж [3], эсхүл файл оруулж болно [4].

# Аудио бичлэг хийх




Аудио бичлэг хийхийн тулд, **Бичлэг хийх** товчийг товшино уу [1].

Бичлэгийг зогсоохын тулд, **Зогсоох** товчийг товшино уу [2].

### Аудио сэтгэгдлийг сонсож үзээд илгээх




Аудиог дахин тоглуулахын тулд, **Тоглуулах** товчийг товшино уу [1]. Аудио бичлэгийг шинээр хийхийн тулд, **Устгах** товчийг дарна уу [2]. Дуусаад **Илгээх** товчийг товшино уу [3].

# Видео бичлэг хийх




Шинэ видео бичлэг хийхийн тулд, **Бичлэг хийх** товчийг товшино уу. Бичлэгийг зогсоохын тулд уг товчийг дахин товшино уу.

**Тайлбар:** Canvas таны микрофонд хандах зөвшөөрөл авч магад.

## Видеог ашиглах




Видеог дахин тоглуулахын тулд, **Тоглуулах** товчийг товшино уу [1]. Хэрэв та бичлэгийг шинээр хийхийг хүсвэл, **Дахин бичих** товчийг товшино уу [2]. Дуусмагц **Видеог ашиглах** товчийг товшино уу [3].

# Файл сонгох




Файл сонгогчийг ашиглах файлаа хавсаргана уу. Эхлээд бичлэг хийгээд дараа нь аппаратны эсхүл видео файл хавсаргахын тулд **Камер** таних тэмдгийг товшино уу [1]. Өөрийн төхөөрөмжийн зургийн сангаас файл хавсаргахын тулд, **Сан** таних тэмдгийг товшино уу [2]. Төхөөрөмж дэх файлаасаа хавсаргахын тулд, **Файлууд** таних тэмдгийг товшино уу [3].

## Сэтгэгдлийг харах




Өөрийн сэтгэгдлийг харна уу.

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа хэрхэн харах вэ??
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгаврынхаа үнэлэх зарчмыг хэрхэн харах вэ??
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор ямар нэг даалгаврын талаар хэрхэн сэтгэгдэл оруулах вэ??

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгаврынхаа үнэлэх зарчмыг хэрхэн харах вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 8-р сарын 9-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 6

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Багш тань даалгаврын нэг хэсэг болгон үнэлэх зарчмыг оруулсан байж магад. Үнэлэх зарчим нь таны даалгаврыг дүгнэхдээ багш тань ашигладаг иж бүрэн шалгуурууд юм. Даалгавраа илгээхийн өмнө та даалгаврын үнэлэх зарчмыг үзэж, таны даалгавар багшийн тавьсан шаардлагыг хангаж байгааг нягтлан өөрийн ажлыг үнэлнэ.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**Зарим даалгаварт үнэлэх зарчим оруулаагүй байж болно.

## Хичээл нээх




Хичээлийн нэрийг товшино уу.

**Даалгаврууд нээх**




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:**Даалгаврууд холбоосыг харахын тулд та гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх




Даалгаврын нэр дээр товшино уу.

## Илгээсэн даалгавар болон үнэлэх зарчмыг нээх




Даалгаврын дэлгэрэнгүй хуудас дээрх **Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим** холбоосыг товшино уу.

## Үнэлэх зарчмыг нээх




**Үнэлэх зарчим** холбоосыг товших

**Тайлбар:**Хэдийгээр багш даалгаварт үнэлэх зарчим хавсаргаагүй байсан ч Үнэлэх зарчим цэс харагдсаар байх болно.

## Үнэлэх зарчим харах




Үнэлэх зарчим цэсэд үнэлэх зарчмын шалгуурууд [1], шалгуурын тодорхойлолтууд [2], болон шалгуурын боломжит үнэлгээнүүд [3] харагдана.

Үнэлэх зарчмын нэмэлт шалгууруудыг харах бол дээш гүйлгэнэ үү.

## Шалгуурын тодорхойлолт харах




Аль нэг шалгуурын тодорхойлолт харах бол, шалгуурын тодорхойлолт холбоосыг [1] товшино уу.

Шалгуурын тодорхойлолт шинэ хуудаснаа гарч ирнэ [2]. Шалгуурын тодорхойлолтыг шалгаж дуусаад, **Дууссан** холбоосыг [3] товшино уу.

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор ямар нэг даалгаврын талаар хэрхэн сэтгэгдэл оруулах вэ?
**Дараагийн сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор илгээх даалгавар болгон файл хэрхэн оруулах вэ?
**Та энд байна**

Table of Contents > Assignments > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгаврынхаа үнэлэх зарчмыг хэрхэн харах вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн аппд илгээх даалгавар болгон файл хэрхэн оруулах вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 8-р сарын 9-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 6

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та даалгавар болгон өөрийн iOS төхөөрөмж дэх файлуудыг оруулах боломжтой. Та даалгавраа илгээсний дараа, даалгавар илгээгдсэн болохыг баталгаажуулах боломжтой. Хэрэв багш тань зөвшөөрсөн тохиолдолд мөн та даалгаврыг дахин илгээх боломжтой.

Түүнчлэн та Google Drive болон Dropbox зэрэг гуравдагч этгээдийн аппнаас даалгавраа илгээж болно.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**

- Багш тань файл оруулах зэрэг даалгавар илгээх зарим төрлийг хязгаарлаж болох учир энэ сонголт таныг даалгавраа илгээхэд гарч ирэхгүй байж болно.
- Хэрэв таны даалгаварт PDF файл руу орох холбоос байгаа бол, та даалгаврынхаа нэг хэсэг болгон тэмдэглэл нэмэх боломжтой.
- Canvas Сурагчийн апп дотор файл гаднаас оруулж болон медиа бичлэг хийж илгээх талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл, Canvas медиа харьцуулалт PDF.баримт бичгийг харна уу.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

## Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх



Даалгаврын нэр дээр товшино уу.

### Даалгаврын дэлгэрэнгүйг харах




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа даалгавар хүлээн авахад зөвшөөрөгдсөн илгээх төрлүүд [1] болон зөвшөөрөгдсөн файлын төрлүүд [2] зэрэг даалгаврын талаарх мэдээлэл байна.

Мөн та Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим холбоосноос даалгаварт сэтгэгдэл үлдээж, хавсаргасан файлууд харж, даалгаврын үнэлэх зарчмыг харах боломжтой [3].

## Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас илгээх




**Даалгавар илгээх** товчийг товшино уу.

## Файл оруулахыг сонгох




**Файл оруулах** холбоосыг товшино уу.

## Оруулах эх үүсвэрийг сонгох




Файл сонгогч ашиглан, өөрийн оруулахыг хүссэн файлын байрших эх үүсвэрийг сонгоно уу.

Өөрийн төхөөрөмжийн камераар зураг авах буюу бичлэг хийх бол, **Камер** холбоосыг товшино уу [1].

Өөрийн төхөөрөмжийн сангаас файл сонгохын тулд, **Сан** холбоосыг товшино уу [2].

Төхөөрөмж дэх файлаасаа файл сонгохын тулд, **Файлууд** холбоосыг товшино уу [3].

# Даалгавар илгээх




Илгээхээр сонгосон файлаа баталгаажуулна уу [1]. Дараа нь **Илгээх** холбоосыг [2] товшино уу.

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгаврынхаа үнэлэх зарчмыг хэрхэн харах вэ?
**Дараагийн сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор илгээх даалгавар болгон медиа файл хэрхэн илгээх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон файл хэрхэн оруулах вэ?

# Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон медиа файл хэрхэн илгээх вэ?

Canvas Doc багийн 2019 оны 8-р сарын 9-ний өдөр боловсруулсан бичиг баримт•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 6

- Таалагдсан • 1 Таалагдсан харуулах 1
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та даалгавар болгон өөрийн iOS төхөөрөмж дэх медиа файлыг оруулах боломжтой. Та даалгавраа илгээсний дараа, даалгавар илгээгдсэн болохыг баталгаажуулах боломжтой. Хэрэв багш тань зөвшөөрсөн тохиолдолд мөн та даалгаврыг дахин илгээх боломжтой.

Түүнчлэн та Google Drive болон Dropbox зэрэг гуравдагч этгээдийн аппнаас даалгавраа илгээж болно.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**

- Багш тань медиа файл оруулах зэрэг зарим даалгавар илгээх төрлийг хязгаарлаж болох учир энэ сонголт таныг даалгавраа илгээхэд гарч ирэхгүй байж болно.
- Canvas Сурагчийн апп дотор файл гаднаас оруулж болон медиа бичлэг хийж илгээх талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл, Canvas медиа харьцуулалт PDF баримт бичгийг харна уу.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

## Даалгаврууд нээх




Даалгаврууд холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх



Даалгаврын нэр дээр товшино уу.

### Даалгаврын дэлгэрэнгүйг харах




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа даалгавар хүлээн авахад зөвшөөрөгдсөн илгээх төрлүүд [1] болон зөвшөөрөгдсөн файлын төрлүүд [2] зэрэг даалгаврын талаарх мэдээлэл байна.

Мөн та Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим холбоосноос даалгаварт сэтгэгдэл үлдээж, хавсаргасан файлууд харж, даалгаврын үнэлэх зарчмыг харах боломжтой [3].

## Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас илгээх




**Даалгавар илгээх** товчийг товшино уу.

## Медиа бичлэг сонгоно уу




**Медиа бичлэг** холбоосыг товшино уу.

**Бичлэг хийх төрлийг сонгох**




Өөрийн төхөөрөмжийг ашиглан аудио бичлэг хийхийн тулд, **Аудио бичлэг хийх** товчийг дарна уу [1].

Өөрийн төхөөрөмжийг ашиглан видео бичлэг хийхийн тулд, Видео бичлэг хийх товчийг дарна уу [2].

# Аудио файл бичих




**Бичлэг хийх** таних тэмдгийг дарж бичиж эхлэнэ үү [1]. Бичлэг хийх явцад, дэлгэцийн дээр байрлах цаг таны бичлэгийн уртыг илэрхийлнэ [2]. Бичлэгийг зогсоохын тулд, **Зогсоох** товчийг товшино уу [3].

### Аудио файлыг сонсож үзэх




Бичлэг хийхээ зогсоосны дараа та аудио файлаа сонсож үзэх боломжтой.

### Аудио файл илгээх




Файлаа устгаад дахиад эхлэхийн тулд, **Устгах** товчийг товшино уу [1]. Илгээх даалгавар болгон аудио бичлэг илгээхийн тулд, **Илгээх** товчийг товшино уу [2].

## Видео файл бичих




Бичиж эхлэхийн тулд **Бичлэг хийх** таних тэмдгийг дарна уу [1]. Бичлэг хийх явцад, дэлгэцийн дээр байрлах цаг таны бичлэгийн уртыг илэрхийлнэ [2]. Бичлэгийг зогсоохын тулд, **Зогсоох** товчийг товшино уу [3].

## Видео файлыг үзэх




Бичлэг хийхээ зогсоосны дараа та видео файлаа үзэх боломжтой.

## Видео файл илгээх




Файлаа устгаад дахиад эхлэхийн тулд, **Дахин бичих** товчийг товшино уу [1]. Илгээх даалгавар болгон видео бичлэг илгээхийн тулд, **Видеог ашиглах** товчийг товшино уу [2].

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон файл хэрхэн оруулах вэ?
**Дараагийн сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон вэб хуудасны URL хаяг хэрхэн оруулах вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон медиа файл хэрхэн илгээх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар.вэб хуудасны URL хаяг хэрхэн оруулах вэ?

Баримт бичгийг Canvas Doc багийн 2019 оны 8-р сарын 9-ний өдөр боловсруулсан•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 6

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та илгээх даалгавар болгон вэб хуудасны URL хаягийг iOS төхөөрөмжөөсөө илгээх боломжтой. Та даалгавраа илгээсний дараа, даалгавар илгээгдсэн болохыг баталгаажуулах боломжтой. Хэрэв багш тань зөвшөөрсөн тохиолдолд мөн та даалгаврыг дахин илгээх боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**Багш тань URL оруулах зэрэг даалгавар илгээх зарим төрлийг хязгаарлаж болох учир энэ сонголт таныг даалгавраа илгээхэд гарч ирэхгүй байж болно.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

## Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх



Даалгаврын нэр дээр товшино уу.

**Даалгаврын дэлгэрэнгүйг харах**




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа даалгавар хүлээн авахад зөвшөөрөгдсөн илгээх төрлүүд [1] болон зөвшөөрөгдсөн файлын төрлүүд [2] зэрэг даалгаврын талаарх мэдээлэл байна.

Мөн та Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим холбоосноос даалгаварт сэтгэгдэл үлдээж, хавсаргасан файлууд харж, даалгаврын үнэлэх зарчмыг харах боломжтой [3].

# Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас илгээх




**Даалгавар илгээх** товчийг товшино уу.

## Вэб хуудасны URL сонгох




**Вэб хуудасны URL** холбоосыг товшино уу.

# URL оруулах



Вэб хуудасны URL хаягаа вэб хуудасны текстийн хайрцагт шивэх буюу буулгана уу [1].

Та тухайн холбоосыг агуулгыг **Үзэх** нүдэнд үзэх боломжтой [2].

Та даалгавраа илгээхэд бэлэн болсны дараа, **Илгээх** холбоосыг товшино уу [3].

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор илгээх даалгавар болгон медиа файл хэрхэн илгээх вэ?
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор текст оруулах даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон вэб хуудасны URL хаяг хэрхэн оруулах вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор текст оруулах даалгавраа хэрхэн илгээх вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 8-р сарын 9-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 6

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Хэрэв багш тань текст оруулах хэлбэрээр даалгавар илгээхийг зөвшөөрсөн бол, та өөрийн iOS төхөөрөмжөө ашиглан илгээх даалгавар болох текстээ шивэх буюу хуулаад буулгах боломжтой. Та даалгавраа илгээсний дараа, даалгавар илгээгдсэн болохыг баталгаажуулах боломжтой. Хэрэв багш тань зөвшөөрсөн тохиолдолд мөн та даалгаврыг дахин илгээх боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

## Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх



Даалгаврын нэр дээр товшино уу.

**Даалгаврын дэлгэрэнгүйг харах**




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа даалгавар хүлээн авахад зөвшөөрөгдсөн илгээх төрлүүд [1] болон зөвшөөрөгдсөн файлын төрлүүд [2] зэрэг даалгаврын талаарх мэдээлэл байна.

Мөн та Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим холбоосноос даалгаварт сэтгэгдэл үлдээж, хавсаргасан файлууд харж, даалгаврын үнэлэх зарчмыг харах боломжтой [3].

# Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас илгээх




**Даалгавар илгээх** товчийг товшино уу.

## Шивсэн текстийг сонгох




**Текст оруулах** холбоосыг товших.

## Текст оруулах




Өөрийн текстийг **Даалгавар оруулах** нүдэнд шивэх буюу буулгана уу.

# Оруулсан текст илгээх



Та оруулсан текстээ илгээхэд бэлэн болсон бол **Илгээх** холбоосыг товшино уу.

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ илгээх даалгавар болгон вэб хуудасны URL хаяг хэрхэн оруулах вэ?
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор Canvas Studio даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор текст оруулах даалгавраа хэрхэн илгээх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор тэмдэглэл бүхий PDF даалгавраа хэрхэн илгээх вэ?

Canvas Doc багийн 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав Хувилбар 39

- Таалагдсан •  0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Canvas танд илгээх гэж буй даалгаврын PDF файл дээрээ тэмдэглэл хийх боломж олгодог. Хийж болох тэмдэглэлүүд нь тодруулах, доогуур нь зураас татах, хөвөө зурах, баллах, чөлөөт текст оруулах болон зурах.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

**Даалгаврууд нээх**




Даалгаврууд холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх




Нээхийг хүссэн даалгавраа товшино уу.

## Холбоос нээх




Даалгаврын тодорхойлолтын нүдэн дэр файлын холбоосыг товшино уу.

## PDF засварлах




**Засварлах** таних тэмдгийг товшино уу.

## Багаж хэрэгслүүдийг харах




Багаж хэрэгслүүдийг ашиглан тэмдэглэл хийх багажаа сонгоно уу.

Тодруулах, доогуур зураас татах, мушгирсан хөвөө зурах, эсхүл баллах, текстэн тэмдэглэл хийхийн тулд, **Текст форматлах** таних тэмдгийг товшино уу [1].

Текст шивэх эсхүл сэтгэгдэл нэмэхийн тулд, **Чөлөөт текст** таних тэмдгийг товшино уу [2].

Дүрс зурах эсхүл өнгөөр тэмдэглэх бол **Үзэг** таних тэмдгийг товшино уу [3].

Өөрчлөлтүүдийг буцаахын тулд, **Буцаах** таних тэмдгийг товшино уу [4].

Сум, зураас зурах эсхүл дүрсэн тэмдэглэл хийх бол, **Зураас** таних тэмдгийг товшино уу [5].

Тэмдэглэл болгон холбоос нэмэх бол, **Холбоос** таних тэмдгийг товшино уу [6].

Тэмдэглэлээ буцаах эсхүл буцааснаа эргэж сэргээх бол, **Сум** таних тэмдгүүдийг товшино уу [7].

Багаж хэрэгслийг хаахын тулд, **Хаах** таних тэмдгийг товшино уу [8].

Багаж хэрэгслийг зөөхийн тулд товшоод, товшсон хэвээр нь бариулыг чирч [9], шинэ байршилд аваачна. Багаж хэрэгслийг дэлгэцийн аль ч талд байрлуулах боломжтой.

# Текстэн тэмдэглэл хийх багаж ашиглах



Текстэн тэмдэглэл хийх сонголтуудыг харахын тулд, **Текст форматлах** таних тэмдгийг товшоод барина уу [1].

Текст форматлах боломжууд нь текстийг тодруулах [2], доогуур нь зураас татах [3], мушгирсан хөвөө зурах [4], баллах [5].

## Текстэн тэмдэглэлийн өнгө өөрчлөх



Текстэн тэмдэглэлийн багажийн өнгө өөрчлөх бол, өнгө таних тэмдгийг [1] товшоод, дараа нь сонгох өнгөө товшино уу [2]. Цэсийг нууж, тэмдэглэлийг нэмэхийн тулд цэсийг доош нь гүйлгэнэ үү [3].

# Чөлөөт текстэн тэмдэглэлийн багажийг ашиглах




Текстэн тэмдэглэл хийх боломжуудыг харахын тулд **Чөлөөт текст** таних тэмдгийг товшоод барина уу [1]. Та текст нэмэх [2] эсхүл сэтгэгдэл нэмэх [3] сонголт хийж болно.

### Чөлөөт текст форматлахыг сонгох



Текстэн тэмдэглэлээ форматлахын тулд өнгө таних тэмдгийг товшино уу [1]. Та форматлах боломжуудаа Жишээ нүдэнд [2] харах боломжтой. Та фонтны хэмжээг [3] болон өнгийг [4] өөрчлөх боломжтой. Эдгээр сонголтуудыг нууж, тэмдэглэлээ нэмэх бол, цэсийг доош гүйлгэнэ үү [5].

## Тэмдэглэлийн багаж үзгийг ашиглах




Үзэг багажийн боломжуудыг харахын тулд, **Үзэг** таних тэмдгийг товшино уу [1]. Та нарийн зураас [2], өргөн тод зураас [3], болон дүрснүүд [4] зурах боломжтой.

### Үзгээр форматлахыг сонгох



Үзгийн тэмдэглэлүүдээ форматлахын тулд өнгөний таних тэмдгийг товшино уу [1]. Та форматлах боломжуудаа Жишээ нүдэнд [2] харах боломжтой. Та үзгийн өргөн нарийн [3] , өнгийг [4] тохируулах боломжтой. Өнгөний өөр боломжуудыг харахын тулд Өнгө цэсийг товшино уу [5].

Эдгээр сонголтуудыг нууж, тэмдэглэлээ нэмэх бол цэсийг доош гүйлгэнэ үү [6].

# Тэмдэглэл хийх багаж зураасыг ашиглах




Зураасан тэмдэглэл хийх боломжуудыг харахын тулд **Зураас** таних тэмдгийг товшоод барина уу [1]. Та сум [2], зураас [3], болон дүрсүүд [4] зурах боломжтой. Дүрсний илүү их боломжуудыг харахын тулд сум дээр товшино уу [5].

### Зураасаар форматлахын сонгох




Зураасан тэмдэглэлүүдээ форматлахын тулд өнгөний таних тэмдгийг товшино уу [1]. Та форматлах боломжуудаа Жишээ нүдэнд [2] харах боломжтой. Та зураасны өргөн нарийныг [3] болон өнгийг [4] тохируулах боломжтой. Өнгөний өөр боломжуудыг харахын тулд Өнгө цэсийг товшино уу [5].

Эдгээр сонголтуудыг нууж, тэмдэглэлээ нэмэх бол, цэсийг доош гүйлгэнэ үү [6].

## Тэмдэглэлийн багаж Холбоосыг ашиглах




Та тэмдэглэл хэлбэрээр холбоос оруулах боломжтой. **Холбоос** таних тэмдгийг товшино уу [1]. Дараа нь товшоод товшсон чигтээ чирэн холбоос нэмэхийг хүссэн шинэ байршилд аваачна уу [2].

## Холбооснууд үүсгэх




Ижилхэн баримт бичиг дээрх өөр хуудас руу сонгосон хэсгээс холбоос үүсгэхийн тулд, **Хуудас руу холбох** сонголтыг товшино уу [1]. Хуудасны дугаар [2] оруулах буюу сонгох хуудсаа товшино уу [3].

Сонгосон хэсэгтээ вэб хуудасны холбоос нэмэхийн тулд, **Вэб хуудас руу холбох** сонголтыг товшино уу [4]. Вэб хуудасны хаяг оруулах нүдэнд URL оруулна уу [5]. Вэб хуудсыг харах цонхноос агуулгыг харна уу [6].

## Тэмдэглэлүүдийг хаах




Тэмдэглэл оруулж дуусаад **Хаах** таних тэмдгийг товших [1] буюу **Засварлах** таних тэмдгийг товшино уу [2].

# Хуваалцах цэсийг нээх




**Хуваалцах** таних тэмдгийг товшино уу.

# Даалгавар илгээх




**Даалгавар илгээх** товчийг товшино уу.

## Даалгаварт илгээх сэтгэгдэл нэмэх




Даалгаварт илгээх сэтгэгдлийг Сэтгэгдэл нүдэнд шивнэ үү.

### Даалгавар илгээх




**Илгээх** холбоосыг товшино уу.

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор Canvas Studio даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Дараагийн сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп руу гуравдагч этгээдийн апп дахь даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор тэмдэглэл бүхий PDF даалгавраа хэрхэн илгээх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп руу гуравдагч этгээдийн аппаас даалгавраа хэрхэн илгээх вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 37

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Canvas нь Google Drive, Dropbox болон Microsoft OneDrive зэрэг гуравдагч этгээдийн аппууд дахь даалгаврыг тань холбох замаар өөрийн төхөөрөмжөөс тэдгээрийг илгээхэд хялбар болгож өгдөг.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**

- Canvas Сурагчийн апп руу даалгавар оруулахын өмнө:
  - даалгавар тань хэдийнээ гуравдагч этгээдийн апп руу орсон байх ёстой.
  - гуравдагч этгээдийн апп таны iOS төхөөрөмж дээр суусан байх ёстой.
- Canvas Сурагчийн апп дотор файл гаднаас оруулах талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл, Canvas медиа харьцуулалт PDF баримт бичгийг харна уу.

## Гуравдагч этгээдийн апп нээх




Өөрийн iOS төхөөрөмж дээрх гуравдагч этгээдийн апп дээр товшиж нээнэ үү.

## Dropbox аппнаас илгээх




Canvas даалгавар болгон илгээхийг хүссэн файлаа олно уу [1]. Файлын нэрийн хажууд байгаа **Боломжууд** таних тэмдгийг товшино уу [2].

### Dropbox файл экспортлох




**Экспортлох** холбоосыг товшино уу.

### Апп дотор нээх




**...дотор нээх** холбоосыг [1] товшино уу. Дараа нь **Даалгавар илгээх** холбоосыг [2] товшино уу.

## Google Drive аппнаас илгээх




Canvas даалгавар болгон илгээхийг хүссэн файлаа олно уу [1]. Дараа нь файлын нэрийн хажууд байгаа Боломжууд таних тэмдгийг товшино уу [2].

### Canvas дотор файлыг нээх




**...дотор нээх** холбоосыг [1] товшино уу. Файлыг экспортлоход бэлэн болсны дараа, **Даалгавар илгээх** холбоосыг [2] товшино уу.

## Microsoft OneDrive аппнаас илгээх



Canvas даалгавар болгон илгээхийг хүссэн файлын нэр дээр товшино уу [1]. Дараа нь **Хуваалцах** таних тэмдгийг [2] товшино уу.

### Canvas руу хувийг илгээх




**Хувийг илгээх** холбоосыг [1] товшино уу. Дараа нь **Даалгавар илгээх** холбоосыг [2] товшино уу.

## Хичээл сонгох




**Хичээл** цэсийг [1] товшино уу. Хичээлийн жагсаалтад таны одоогийн бүх Canvas хичээлүүд харагдана. Даалгаврыг илгээх хичээлийг сонгохын тулд хичээлийн нэр дээр товшино уу [2]. Таны сонгосон хичээл дээр зөв тэмдэг гарч ирнэ [3].

## Даалгавар сонгох




Даалгавар цэсийг товшино уу [1]. Даалгаврын жагсаалтад таны хичээлийн бүх даалгаврууд үсгийн дараалалд оруулсан байдлаар харагдана. Таны илгээж буй даалгавар аль даалгаврынх болохыг нэр дээр нь товшиж сонгоно уу [2]. Таны сонгосон даалгавар дээр зөв тэмдэг гарч ирнэ [3].

**Тайлбар:**Даалгаврын жагсаалтад түгжээтэй байгаа даалгаврыг оролцуулаад бүх даалгавар харагдана.

## Илгээх даалгаварт сэтгэгдэл нэмэх




Илгээх даалгавартаа сэтгэгдэл нэмэхийн тулд, **Сэтгэгдэл…** нүдийг товшино уу.

## Даалгавар илгээх




Даалгавраа илгээхийн тулд **Илгээх** товчийг товшино уу.

## Сурагчийн апп дотор амжилттай илгээгдсэн болохыг харах




Та Canvas Сурагчийн апп дотор Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас таны даалгавар [илгээгдсэн болохыг баталгаажуулах] боломжтой.

**Тайлбар:**Хэрэв та түгжээтэй даалгаварт зориулан файл илгээхийг оролдсон тохиолдолд Даалгаврын дэлгэрэнгүй хуудасны илгээлт амжилттай болсон тухай мэдэгдэл ирэхгүй бөгөөд оронд нь даалгавар оруулах боломжтой огноог харуулна.

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор тэмдэглэл бүхий PDF даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Дараах сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа илгээгдсэн болохыг хэрхэн баталгаажуулах вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп руу гуравдагч этгээдийн апп дахь даалгавраа хэрхэн илгээх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа илгээгдсэн болохыг хэрхэн баталгаажуулах вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 39

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та даалгавар илгээх төрлийг харж даалгавар тань зөв илгээгдсэн эсэхийг баталгаажуулах боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

### Даалгаврууд нээх




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх




Даалгаврын нэр дээр товшино уу.

## Даалгаврын дэлгэрэнгүй хуудсыг харах




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа даалгавар амжилттай илгээгдсэн огноо цаг тэмдэглэгдсэн байгаа.

## Илгээсэн даалгавар болон үнэлэх зарчмыг нээх




Илгээсэн даалгавраа харахын тулд доош гүйлгэж **Илгээсэн даалгавар болон үнэлэх зарчим** холбоос дээр товшино уу.

## Илгээгдсэн даалгавар харах




Илгээгдсэн даалгавар хуудаснаа таны зөвхөн хамгийн сүүлд илгээсэн даалгавар харагдана [1]. Өмнө илгээсэн даалгаврыг харахын тулд сум таних тэмдгийг [2] товшоод, дараа нь жагсаалтаас даалгавраа сонгоно уу [3].

### Даалгавар хураалгах




Хэрэв танд илгээсэн аливаа даалгавар байхгүй бол та **Даалгавар илгээх** товчийг товших замаар даалгавар хураалгах боломжтой.

**Өмнөх сэдэв:**Би өөрийн iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп руу гуравдагч этгээдийн апп дахь даалгавраа хэрхэн илгээх вэ?
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавраа хэрхэн дахин илгээх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа илгээгдсэн болохыг хэрхэн баталгаажуулах вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавраа хэрхэн дахин илгээх вэ?

Canvas Doc багийн 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав Хувилбар 38

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Хэрэв багш тань даалгаврыг дахин илгээхийг зөвшөөрсөн бол та даалгавраа дахин илгээх боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

**Даалгаврууд нээх**




**Даалгаврууд** холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх хэрэгтэй байж магад.

## Даалгавар нээх




Даалгаврын нэр дээр товшино уу.

### Илгээсэн даалгаврын дэлгэрэнгүй мэдээллийг харах




Даалгаврын дэлгэрэнгүй мэдээлэл хуудаснаа таны илгээсэн даалгаврын дэлгэрэнгүй харагдана.

## Даалгавар дахин илгээх




**Даалгавар дахин илгээх** товчийг товшино уу.

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавруудаа илгээгдсэн болохыг хэрхэн баталгаажуулах вэ???
**Дараах сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавартаа хэрхэн тэмдэглэл нэмэх вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавраа хэрхэн дахин илгээх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавартаа хэрхэн тэмдэглэл нэмэх вэ?

Баримт бичгийг Canvas Doc багийн ажилтан2018 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулав•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 23

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та илгээх даалгаварт тэмдэглэл нэмэх боломжтой байж магад. Canvas DocViewer нь илгээсэн онлайн даалгавар дотор тэмдэглэл хийх боломж бүрдүүлдэг арга хэрэгсэл юм. Canvas Сурагчийн апп дотор хийсэн тэмдэглэлийг багш тань таны даалгаврыг дүгнэхдээ харах боломжтой.

Хэрэв аливаа файл DocViewer программтай нийцэмжгүй бол баримт бичгийг харуулагч нь файлыг харуулах хэдий ч DocViewer тэмдэглэл болон сэтгэгдэл үлдээх боломжгүй байх болно.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

**Тайлбар:**

- Хэмжээ нь 100 MB хэтэрсэн файл болон нууц үгээр хамгаалагдсан файлуудыг DocViewer хувиргахгүй.
- Даалгаврыг илгээснээс хойш арав хүртэл минут болсны дараа Сурагчийн апп нь DocViewer программаар ажиллах боломжтой баримт бичгийг харуулах болно.

## Илгээсэн даалгаврыг нээх




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаас **Илгээсэн даалгавар болон Үнэлэх зарчим** холбоосыг товшино уу.

## Файлд тэмдэглэл хийх




**Тэмдэглэл хийх** таних тэмдгийг товшино уу.

# Тэмдэглэл хийх багажийг харах




Тэмдэглэл хийх таних тэмдгийг товшиж, тэмдэглэл хийх багажийг сонгоно уу [1]. Сонгосны дараа таних тэмдгийн ар цагаан байх болно. Тэмдэглэл хийх багажийг ашиглахаа зогсоохын тулд Тэмдэглэл хийх таних тэмдгийг дахин товшино уу.

Сүүлд хийсэн үйлдлээ буцаахын тулд **Буцаах** товчийг товшино уу [2].

Хэрэв илгээсэн даалгавар нэгээс илүү хуудастай бол нэмэлт хуудаснуудыг харахын тулд дэлгэцээ дээш нь гүйлгэнэ үү.

## Цэгэн тэмдэглэл нэмэх




Цэгэн тэмдэглэл үлдээхийн тулд, Цэг тэмдэглэлийн таних тэмдгийг товшино уу [1].

Тэмдэглэл нэмэхийг хүссэн газраа товшино уу [2].

## Сэтгэгдэл нэмэх




Цэгэн тэмдэглэлд нэн даруй сэтгэгдэл оруулах шаардлагатай. **Хариулах** нүдэнд [1], цэгэн тэмдэглэлийн сэтгэгдлийг шивж оруулна уу. Илгээх таних тэмдгийг товшино уу [1].




Сэтгэгдлээ устгахын тулд **Устгах** таних тэмдгийг [1] товшино уу. Илгээсэн даалгавар руу буцахын тулд, **Дууссан** холбоосыг [2] товшино уу.

### Цэгэн тэмдэглэлийг өөрчлөх




Тэмдэглэлийг зөөхийн тулд баримт бичиг дэх тэмдэглэл таних тэмдгийг товшоод барина уу [1]. Тэмдэглэлийг чирэн шинэ байршилд аваачна уу.

Тэмдэглэлийн сэтгэгдлийг харж өөрчлөхийн тулд **Сэтгэгдэл** товчийг [2] товшино уу.

Тэмдэглэлийн устгахын тулд **Устгах** таних тэмдгийг [3] товшино уу. Тэмдэглэлийг устгаснаас аливаа холбогдох сэтгэгдлүүд мөн устгагдана.

# Тодруулах тэмдэглэл нэмэх




Баримт бичиг дэх текстийг тодруулахын тулд, **Тодруулах** таних тэмдгийг [1] товшино уу. Тодруулах өнгө сонгохын тулд, **Өнгө** таних тэмдгийг товшино уу [2].

Тодруулах тэмдэглэл нэмэхийн тулд даалгавар дотроо товшоод чирнэ үү [3].

## Тодруулах тэмдэглэл өөрчлөх




Тэмдэглэлийг өөрчлөхийн тулд тухайн тэмдэглэлийг товшоод барина.

Тодруулсан тэмдэглэлд сэтгэгдэл нэмэхийн тулд,  Сэтгэгдэл товчийг [1] товшино уу.Тэмдэглэлийн хэв маягийг өөрчлөхийн тулд **Хэв маяг** товчийг [2] товшино уу.

Тодруулсан тэмдэглэл устгахын тулд **Устгах** таних тэмдгийг [3] товшино уу. Тэмдэглэлийг устгаснаас аливаа холбогдох сэтгэгдлүүд мөн устгагдана.

# Текстэн тэмдэглэл нэмэх




Илгээсэн даалгаварт шууд текст нэмэхийн тулд, **Чөлөөт текст** таних тэмдгийг [1] товшино уу. Текстийн өнгө сонгохын тулд, **Өнгө** таних [2] тэмдгийг товшино уу.

Дараа нь тэмдэглэлийг нэмэхийг хүссэн газраа товшино уу.




Текст нүд [1] дотор, тухайн тэмдэглэлд зориулан оруулахыг хүссэн текстээ оруулна уу. Текстийн хэмжээг өөрчлөхийн тулд, **Үзүүр** холбоосыг товшино уу [2].

Дуусмагц Дууссан холбоосыг [3] товшино уу.

## Текстэн тэмдэглэл өөрчлөх




Тэмдэглэлийг өөрчлөхийн тулд, тэмдэглэлийн текстийн хайрцгийг [1] товшино уу.

Тэмдэглэлийг зөөхийн тулд баримт бичиг дэх тэмдэглэлийн хүрээ дээр товшин барина уу. Тэмдэглэлийг чирэн шинэ байршилд аваачна уу.

Тэмдэглэлд сэтгэгдэл нэмэхийн тулд, **Сэтгэгдэл** товчийг [2] товшино уу.

Текстийн хэмжээ эсхүл өнгийг солихын тулд, **Шалгагч** товчийг [3] товшино уу.

Тэмдэглэл хийсэн текстийг засварлахын тулд, **Засварлах** товчийг [4] товшино уу.

Текстэн тэмдэглэлийг устгахын тулд, **Устгах** таних тэмдгийг [5] товшино уу. Тэмдэглэлийг устгаснаас аливаа холбогдох сэтгэгдлүүд мөн устгагдана.

## Текст баллах тэмдэглэл нэмэх




Текстийг устгах нь зүйтэй болохыг илэрхийлэхийн тулд, **Баллах** таних тэмдгийг [1] товшино уу. Баллах өнгө сонгохын тулд, **Өнгө** таних тэмдгийг [2] товшино уу.

Даалгавар дээр текстийг баллахын тулд товшоод чирнэ үү. Текст дээгүүр балласан зураас гарч ирэх болно [3].

**Тайлбар:** Таны дэлгэцийн хэмжээнээс хамааран, та Баллах таних тэмдгийг Сонголтууд таних тэмдгийг товшсоны дараа харах боломжтой болж магад.

## Текст баллах тэмдэглэл өөрчлөх




Тэмдэглэл өөрчлөхийн тулд, тэмдэглэлийг товшино уу [1].

Сэтгэгдэл нэмэхийн тулд **Сэтгэгдэл** товчийг [2] товшино уу.

Баллах хэрэгслийг тасралтгүй зураас байх эсхүл текстийн арыг тодруулах байхаар сонгох, эсхүл баллах өнгийг эсхүл тэмдэглэлийн тод бүдгийг өөрчлөхийн тулд, **Хэв маяг** товчийг [3] товшино уу.

Балласан тэмдэглэлийн устгахын тулд, **Устгах** таних тэмдгийг [4] товшино уу.

# Зурах тэмдэглэл нэмэх




Чөлөөтэй зурж, тэмдэглэхийн тулд **Зурах** таних тэмдгийг [1] товшино уу. Зурх өнгийг сонгохын тулд, **Өнгө** таних тэмдгийг [2] товшино уу.

Зурж эхлэхийн тулд товшоод чирнэ үү. Чөлөөт хэлбэрийн зурааснууд зурах талбайг заан гарч ирнэ [3]. Зурган тэмдэглэлд та олон зурлага нэмэх боломжтой.

**Тайлбар:** Таны дэлгэцийн хэмжээнээс хамааран, та Зурах таних тэмдгийг Сонголтууд таних тэмдгийг товшсоны дараа харах боломжтой болж магад.

### Зурсан тэмдэглэлийг өөрчлөх




Тэмдэглэлийн өөрчлөхийн тулд, тэмдэглэлийн төрлийг сонгоогүй байх ёстой [1]. Дараа нь тэмдэглэлийг [2] товшино уу. Тэмдэглэлийн зургийн гадуур цэнхэр хүрээтэй болно [3]. Тэмдэглэлийг зөөхийн тулд баримт бичиг дэх зурсан тэмдэглэлийн хүрээ дээр товшин барина уу. Тэмдэглэлийг чирэн шинэ байршилд аваачна уу.

Зурган тэмдэглэлдээ сэтгэгдэл нэмэхийн тулд,**Сэтгэгдэл** товчийг товшино уу [4].

Хүссэн цагтаа зургийг устгахын тулд, **Устгах** таних тэмдгийг [5] дарна уу. Тэмдэглэлийг устгаснаас аливаа холбогдох сэтгэгдлүүд мөн устгагдана.

## Талбайн тэмдэглэл нэмэх




Талбайн тэмдэглэл хийхийн тулд, **Талбай** таних тэмдгийг [1] товшино уу. Талбайн тэмдэглэлийн өнгө сонгохын тулд, **Өнгө** таних [2] тэмдгийг товшино уу.

Даалгавар дахь сонгосон газрыг тойруулан тэгш өнцөгтийг товшоод чирнэ үү. Тэмдэглэлийн газрыг заасан хайрцаг гарч ирнэ.

### Талбайн тэмдэглэлийг өөрчлөх




Тэмдэглэлийн өөрчлөхийн тулд, тэмдэглэлийн төрлийг сонгоогүй байх ёстой [1]. Дараа нь баримт бичиг дэх тэмдэглэлийн товшино уу [2]. Тэмдэглэлийн талбайн гадуур цэнхэр хүрээтэй болно [3].

Тэмдэглэлийг зөөхийн тулд баримт бичиг дэх талбайн тэмдэглэлийн хүрээ дээр товшин барина уу. Тэмдэглэлийг чирэн шинэ байршилд аваачна уу.

Тэмдэглэлд сэтгэгдэл нэмэхийн тулд, **Сэтгэгдэл** товчийг товшино уу [4].

Тэмдэглэлийн өнгийг өөрчлөхийн тулд **Шалгагч** товчийг [5] товшино уу.

Тэмдэглэлийн устгахын тулд, Устгах таних тэмдгийг [6] товшино уу. Тэмдэглэлийг устгаснаас аливаа холбогдох сэтгэрдлүүд мөн устгагдана.

Өмнөх сэдэв:Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавраа хэрхэн дахин илгээх вэ?
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор багшаас ирсэн даалгавар дээрх тэмдэглэлийг хэрхэн харах вэ?
**Та энд байна**
Гарчиг > Даалгаврууд > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавартаа хэрхэн тэмдэглэл нэмэх вэ?

# Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор багшаас ирсэн даалгавар дээрх тэмдэглэлийг хэрхэн харах вэ?

Canvas Doc багийн ажилтан 2017 оны 4-р сарын 19-ний өдөр боловсруулсан баримт бичиг•Сүүлийн өөрчлөлтийг Canvas Doc багийн ажилтан 2020 оны 4-р сарын 6-ны өдөр оруулав
Хувилбар 36

- Таалагдсан • 0 Таалагдсан харуулах 0
- Сэтгэгдэл • 0
- Бүтэн дэлгэцийн төлөвт харах

Та багшаас ирсэн сэтгэгдлийг өөрийн илгээсэн даалгаврын нэг хэсэг байдлаар харах боломжтой.

Түүнчлэн та өөрийн даалгавар дээр сэтгэгдэл оруулах боломжтой.

Энэ хичээл дэх зургуудыг утасны дэлгэцэд зориулсан хэмжээгээр харуулж байгаа бөгөөд өөрөөр заагаагүй бол таблет дээр мөн ижил алхмууд харагдана.

## Хичээл нээх




Самбар дээрээс, харахыг хүссэн хичээлээ товшино уу.

### Даалгаврууд нээх




Даалгаврууд холбоосыг товшино уу.

**Тайлбар:** Даалгаврууд холбоосыг харахын тулд та дэлгэцээ гүйлгэх шаардлагатай байж магад.

## Даалгавар нээх




Даалгаврын нэр дээр товшино уу.

**Даалгаврын дэлгэрэнгүйг харах**




Даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа таны даалгавар хэзээ илгээгдсэн болохыг илтгэх цаг хугацааны тэмдэглэл [1] болон уг даалгаварт өгсөн дүн харагдана [2].

# Илгээсэн даалгавар болон үнэлэх зарчмыг нээх




**Илгээсэн даалгавар & үнэлэх зарчим** холбоосыг товшино уу.

# Илгээгдсэн даалгавар харах




Илгээгдсэн даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа таны зөвхөн хамгийн сүүлд илгээсэн даалгавар харагдана.

# Тэмдэглэлүүд харах




Хэрэг багш тань таны илгээсэн баримтад тэмдэглэл үлдээсэн бол, тэдгээр нь Илгээсэн даалгаврын дэлгэрэнгүй хуудаснаа [1] харагдана.

Тэмдэглэлд сэтгэгдэл орсон байж болно. Тэмдэглэлийг [2] товшоод, дараа нь Сэтгэгдэл холбоосыг [3] товшино уу.

## Тэмдэглэл сэтгэгдлийг харах




Сэтгэдлүүд Сэтгэгдэл хуудаснаа харагдана [1].

Сэтгэгдэлд хариу өгөхийн тулд Хариулах нүдэнд [2] шивээд, дараа нь **Илгээх** товчийг [3] товшино уу. Дуусаад **Дууссан** холбоосыг [4] товшино уу.

## Илгээсэн даалгавар дахь сэтгэгдлүүдийг харах




**Сэтгэгдэл** цэсийг товшино уу [1].

Багшаас тань ирсэн аливаа сэтгэгдэл энэ цонхонд харагдана [2]. Багш тань мөн медиа хэлбэрээр сэтгэгдэл үлдээж болно [3]. Медиа хэлбэрийн сэтгэгдлийг тоглуулахын тулд **Тоглуулах** таних тэмдгийг товшино уу [4].

Түүнчлэн багш тань таны илгээсэн даалгаварт бичиг баримт хавсарган үлдээж болно [5].

Мөн та өөрийн даалгавар дээр сэтгэгдэл үлдээх боломжтой [6].

# Үнэлэх зарчмын холбогдолтой сэтгэгдлийг харах




Багш тань даалгаврын үнэлэх зарчим дээр сэтгэгдэл үлдээхээр шийдэж болно. Үнэлэх зарчим дээрх сэтгэгдлийг харахын тулд **Үнэлэх зарчим** цэсийг дарна уу [1].

Сэтгэгдлүүд үнэлэх зарчмын шалгуурын үнэлгээний доор харагдана [2].

**Өмнөх сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор даалгавартаа хэрхэн тэмдэглэл нэмэх вэ?
**Дараагийн сэдэв:**Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор хэрхэн хэрэглэгчийн хувиар ажиллах вэ?
**Та энд байна**
Table of Contents > Assignments > Би iOS төхөөрөмж дээрээ Сурагчийн апп дотор багшаас ирсэн даалгавар дээрх тэмдэглэлийг хэрхэн харах вэ?